



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



**АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024
ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

АУДИТЫН КОД: АРА-2025/001/НА-СТА-ТЕЗ

2025 он



Аудит хийх үндэслэл, бүрэн эрх, аудитын зорилт:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.4 дэх заалтын дагуу аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх
2. Орон нутгийн 2024 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээ төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх
4. Төрөөс хэрэгжүүлж буй төсвийн бодлогыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх
5. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сангийн Яамнаас Архангай аймгийн 2024 оны төсвийн суурь орлогыг 17,421.1 сая төгрөгөөр, суурь зарлагыг 53,741.1 сая төгрөгөөр хянаж, Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 36,320.0 сая төгрөгөөр, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 12,118.9 сая төгрөгөөр, үүнээс сумдад 7,540.7 сая төгрөгийг хуваарилан баталсан байна.

Харин 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар Архангай аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 33,831.9 сая төгрөгөөр, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 12,690.8 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 сарын 01-ний өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолоор аймгийн төсвийн зарлагыг 71,297.6 сая төгрөгөөр баталсан ба аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 29-ны 07 дугаар тогтоолоор 2023 оны шилжих үлдэгдлийг хуваарилан төсөвт зохицуулалт хийж, аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсвийг тодотгон батлах тухай” 07 дугаар тогтоолоор аймгийн төсвийн нийт зарлагыг 71,486.7 сая төгрөгөөр буюу анх баталсан төсвөөс 189.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.



Аймгийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 85,719.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс 73,194.6 сая төгрөгийг зарцуулж, зардлын гүйцэтгэл 85.4 хувьтай байна. Харин Аймгийн ТЕЗ-ийн нэмэлт санхүүжилтийн дансаар 2024 онд нийт 2,986.2 сая төгрөг зарцуулагджээ.

Аймгийн жилийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 205 арга хэмжээний хүрээнд аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ээс 91.2 хувиар үнэлсэн бөгөөд аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний 06 дугаар тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэжээ.

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ НИЙТ ДҮНГЭЭР
134.1 ХУВИАР БУЮУ 8,390.1 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА**

Тайлант жилд орон нутгийн орлогод 2 удаагийн тодотгол хийгдэж аймгийн төсвийн орлогыг 1,430.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 22,448.0 сая төгрөгөөр тодотгон, сумд орон нутгийнхаа онцлог байдалтай уялдуулан хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд 12 нэр төрлийн орлогыг 2,144.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн ТЕЗ-ийн төсвийн нийт орлого 24,592.9 сая төгрөг болж, Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн фискал /fiscal/ программд төлөвлөгдсөн байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2024 он			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	24,592.9	32,983.0	8,390.1	134.1
УРСГАЛ ОРЛОГО	24,560.0	32,852.9	8,292.9	133.8
1.ТАТВАРЫН ОРЛОГО	22,032.0	28,774.8	6,742.8	130.6
2.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,528.1	4,078.1	1,550.0	161.3
3.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	32.9	130.1	97.3	396.1

Орон нутгийн төсвийн орлого гүйцэтгэлээр 32,983.0 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөө 134.1 хувиар буюу 8,390.1 сая төгрөгөөр давж биелсэн байна. 2024 оны төсвийн орлогын төлөвлөлт 2022 оноос 8,857.2 сая төгрөгөөр, 2023 оноос 4,732.6 сая төгрөгөөр, харин орлогын гүйцэтгэл 2022 оноос 14,722.1 сая төгрөгөөр, 2023 оноос 11,246.3 сая төгрөгөөр өсжээ.

2024 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна



Татварын 17, татварын бус 4, хөрөнгийн 1, нийт 22 нэр төрлийн орлого 0.1-2,974.0 сая төгрөгөөр буюу нийт 8,999.2 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд өндөр дүнгээр давж биелсэн татварын болон татварын бус орлогыг тодруулбал:

- **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын татвар** 2,974.0 сая төгрөгөөр давж биелсэн нь төрийн албан хаагчдын үндсэн цалинг Засгийн газрын 128 дугаар тогтоолоор 10 хувь нэмсэн, хөдөө орон нутагт 5 ба түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад Засгийн газрын 83 дугаар тогтоолоор мөнгөн урамшуулал олгосон холбоотой байна.
- **Нэр заагдаагүй бусад орлого** 1,335.9 сая төгрөгөөр давж биелсэн нь Булган, Цэнхэр, Жаргалант, Тариат, Ихтамир сумд тус орлогыг өндөр дүнгээр давуулан биелүүлсэн нь нөлөөлсөн байна.
- **Шууд бус орлого** 1,191.8 сая төгрөгөөр давж биелсэн нь “Эрдэнэс таван толгой” ХК-ний ногдол ашиг хуваарилсантай холбоотой байна.
- **Торгуулийн орлого** 530.9 сая төгрөгөөр давж биелсэн нь татварын цахим систем, цахим банкны үйлчилгээг ашиглан автомашины торгуулийг хурдан шуурхай төлөх боломжтой болж, орлого төвлөрсөнтэй холбоотой.
- **Ойн нөөц ашигласны төлбөр** 464.5 сая төгрөгөөр давж биелсэн нь Булган, Цэнхэр, Жаргалант, Ихтамир сумдтай ААН-үүд гэрээ хийж хуш модны самрыг үйлдвэр, аж ахуйн зориулалтаар ашиглан борлуулж ажилласантай холбоотой байна.

Татварын 3 нэр төрлийн, татварын бус 1, нийт 4 нэр төрлийн орлогыг төлөвлөснөөс 0.1 - 508.9 сая төгрөгөөр буюу нийт 609.1 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлжээ. Дэлгэрэнгүй танилцуулбал:

- **Хүүгийн орлого:** 508.7 сая төгрөгөөр тасарсан нь Засгийн газрын дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлттэй холбоотойгоор Сангийн Яамнаас орон нутгийн суурь орлого дээр нэмж 508.7 сая төгрөгөөр хянасан бөгөөд тус орлогыг Архангайн ус суваг ОНӨААТҮГ нь төлөх эх үүсвэргүй, алдагдалтай ажиллаж байгаатай холбоотой байна.
- **Газрын дуудлага худалдааны орлого:** 80.8 сая төгрөгөөр тасарсан нь зарим сумдад дуудлага худалдаагаар төлөвлөгдсөн газрын байршлууд нь ой, ус, зам, эрчим хүчний шугам зэрэг хамгаалалтын зурвастай давхацсан, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй зөрчилдсөн зэргээс шалтгаалж хүчингүй болсонтой холбоотой байна.
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр:** 19.5 сая төгрөгөөр тасарсан нь Тариат сумын цагаан толгойн хүрмэн чулуу, Ихтамир сумын Элстэй дэх элсийг ашиглуулахыг сумын ИТХ-аас хориглосон нь нөлөөлсөн байна.



Архангай аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлт:

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар орлогын төлөвлөлт, бүрдүүлэлттэй холбоотой нийт 207.4 сая төгрөгийн зөрчил илэрч, 98.9 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага 108.5 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж хүргүүлсэн байна.

БҮЛЭГ 2: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛСАН БАЙНА

Б.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн зардлын саналыг Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн удирдамжийн дагуу боловсруулж хүргүүлсэн ба саналыг 15.0 хувиар нэмэгдүүлж хянасан байна

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжид заасны дагуу Архангай аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн суурь зарлагын төслийг 46,726.3 сая төгрөгөөр боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8.4.3 дахь заалтын дагуу Сангийн яаманд хүргүүлснийг 7,014.8 сая төгрөгөөр буюу 15.0 хувиар нэмэгдүүлэн 53,741.1 сая төгрөгөөр хянасан байна.

Хүснэгт : Сангийн яаманд хүргүүлсэн, анх болон тодотгон хянасан 2024 оны суурь зарлагын судалгаа

Код	Зардлын ангилал	Хүргүүлсэн санал	Сангийн яамны		Зөрүү	
			Анх хянасан	Тодотголоор хянасан	Санал ба анх хянасны /2-1/	Анх хянасан ба тодотголын /3-2/
А			2	3	4	5
24	ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА	46,726.3	53,741.1	55,059.1	7,014.8	1,318.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,726.3	53,741.1	55,059.1	7,014.8	1,318.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,726.3	50,232.8	51,550.8	3,506.5	1,318.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	3,508.3	3,508.3	3,508.3	0.0

Төсвийн зарлагын баталсан дүнгийн тухайд: Сангийн яамнаас төсвийн тодотголоор аймгийн суурь орлогыг 3,806.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 21,227.2 сая төгрөг, суурь зарлагыг 1,318.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 55,059.1 сая төгрөгөөр хянасан байна. Үүнд үндэслэн УИХ-аас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар улсын төсвөөс аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 33,831.9 сая төгрөгөөр баталсан байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангасан байна

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 сарын 01-ний өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 08 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 4,037.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 их засварын ажлыг тайлант онд 3,508.3 сая төгрөгөөр, авто замын сангийн хөрөнгөөр нэг арга хэмжээг 1,157.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан байна. Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Аймгийн 2024 оны төсвийг тодотгон батлах тухай” 07 дугаар тогтоолоор их засварын ажлын тоог нэгээр нэмж, төсвийг 102.6 сая төгрөгийг бууруулсан ба авто замын сангаар 240.0 сая төгрөгийн 2 ажил нэмж хэрэгжүүлэхээр төсвийг тодотгон баталсан байна.

Анх баталсан болон тодотгосон мэдээллийг хүснэгтээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр	Анх баталсан		Тодотгосон		Өөрчлөлт	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ОНТХО - Их засвар	13	3,508.3	14	3,405.7	1	(102.6)
2	Авто замын сан	1	1,157.6	3	1,397.6	2	240
Дүн		14	4,665.9	17	4,803.3	3	137.4



Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/302 дугаар захирамжаар төсвийг олон нийтийн оролцоотой төлөвлөх, иргэдээр хэлэлцүүлэх ажлын хэсгийг байгуулжээ. Ажлын хэсгээс "Соёлын хөгжил" форум, "Боловсролын хөгжил" форум, "Эрүүл мэндийн хөгжил" форум, "Байгаль орчин, аялал жуулчлалын хөгжил" форум, "Архангай-100 тариаланчдын хэлэлцүүлэг"-ийг зохион байгуулж форумд оролцогчдоос давхардсан тоогоор 620 гаруй саналыг авч нэгтгэсэн. Мөн 19 сумын ЗДТГ, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, агентлаг байгууллагуудаас санал авч нэгтгэн хэрэгцээ шаардлагыг тодорхойлон эрэмбэлэн ажилласан байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд батлагдсан урсгал зардлаас зохицуулалт хийлгүйгээр зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна



Аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн нийт зарлага фискал /fiscal/ программд / төсвийн гүйцэтгэлийн тайлангаар/ 85,719.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 73,194.6 сая төгрөгийг зарцуулан, төсвийн гүйцэтгэл 85.4 хувьтай тайлагнагджээ. Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын төлөвлөгөөний дүнг аймгийн ИТХ-аар баталсан дүн (71,486.7 сая.төгрөг)-өөс 14,233.0 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь сумдын ИТХ-ын хурал бүрэн эрхийн хүрээнд дараах арга хэмжээг авсан хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.



Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг зардлын нэр төрлөөр өмнөх онтой харьцуулж хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт :Орон нутгийн 2024 оны төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа


сая төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл		2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл				Тайлант оны төлөвлөгөө өмнөх оны төлөвлөгөөнөөс	Тайлант оны гүйцэтгэл өмнөх оны гүйцэтгэлээс
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь		
0	1	2	3	4	5	6	7=3-1	8=4-2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	64,892.5	55,072.7	85,719.7	73,194.6	12,525.1	85.4	20,827.2	18,121.9
А. Урсгал зардал	38,880.8	36,458.4	57,883.5	52,762.5	5,121.0	91.2	19,002.7	16,304.1
Б. Хөрөнгийн зардал	20,283.7	16,202.7	23,922.5	19,763.5	4,159.0	82.6	3,638.8	3,560.8
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	5,728.0	2,411.6	3,913.7	668.6	3,245.1	17.1	(1,814.3)	(1,743.0)

Хүснэгтээс харахад тайлант оны төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө өмнөх оноос 20,827.2 сая төгрөг буюу 33.1 хувь, гүйцэтгэл 18,121.9 сая төгрөгөөр буюу 32.9 хувиар өссөн байна.

Тайлант онд төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10.0 хувь, орон нутгийн нэмэгдлийг сумын албан хаагчдын хувьд үндсэн цалингийн 40.0 хувь, аймгийн төвийн албан хаагчдын хувьд 20.0 хувиар тооцон нэмэгдүүлж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон, аймагт нэгдсэн эмнэлгийн барилга шинээр ашиглалтад орж халаалтын зардлын

дүн нэмэгдсэн, их засвар болон орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийн өмнөх оноос нэмэгдсэн зэрэг нь нөлөөлсөн байна.





Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн зарлагын 67.5 хувийг урсгал зардалд, 27.9 хувийг хөрөнгийн зардалд 4.6 хувийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар төлөвлөн зарцуулсан байна.

Нийт 85,719.7 сая төгрөгийн зарлагын 58,143.9 сая төгрөг буюу 67.8 хувийг орон нутгийн төсвөөс, 12,690.8 сая төгрөг буюу 14.8 хувийг ОНХС-аас, 11,013.5 сая төгрөг буюу 12.9 хувийг урьд оны үлдэгдлээс, 3,871.5 сая төгрөг буюу 4.5 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр хуваарилж, зарцуулсан байна



Хөтөлбөр хэрэгжүүлэх зардлын гүйцэтгэл:

Аймгийн ТЕЗ-аас хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээнд анх 1,724.7 сая төгрөг, төсвийн тодотголоор 102.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,827.3 сая төгрөг зарцуулахаар баталж, гүйцэтгэлээр 1,705.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Илрүүлэлт №1

Тайлант онд аймгийн засаг даргын ерөнхий дансанд хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг ерөнхий байдлаар төлөвлөж, баталж зарцуулсан нь төсвийн хөрөнгийг зориулалт бус, үр дүнгүй зарцуулах эрсдэлийг бий болгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.



ТЕЗ-аас хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний зардлыг аймгийн хөгжлийн төлөвлөгөө, засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан, эх үүсвэрийг зардлын зүйлээр нарийвчлан тодорхой төлөвлөж хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Хотын нийтийн хүн тээврийн зардлын гүйцэтгэл:

Тайлант онд аймгийн засаг даргын ерөнхий дансанд хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээнд 358.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж баталж 357.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Илрүүлэлт №2

Гүйцэтгэгч байгууллагаас шаардлага хангасан хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлсэн иргэдийн тоо, холбогдох урсгал зардлын нарийвчилсан тооцоог нотлох санхүүгийн анхан шатны баримтыг ирүүлээгүй, үйлчлүүлсэн иргэдийн тоо, гарсан зардлыг хянах боломжгүй байхад нийт 357.0 сая төгрөгийн санхүүжилтийг тооцон олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв



байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 -д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.



Хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээний зарцуулалтыг анхан шатны баримт, үндэслэлтэй тооцоо судалгаанд үндэслэн санхүүжилтийг олгож, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Төсвийн шууд захирагчийн аудитын илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгийн зарцуулалт, дотоод хяналттай холбоотой 422.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 325.5 сая төгрөгийн зөрчилд 41 албан шаардлага, 97.1 сая төгрөгийн зөрчилд 32 төлбөрийн акт тогтоосон байна.

Зөрчлийг ангилбал:

Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, төсөвт зохицуулалт хийлгүйгээр төсвийг зориулалт бус зарцуулсан, дотоод хяналт хэрэгжүүлээгүйгээр 235.6 сая төгрөг

Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, томилолт, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох урамшууллыг илүү, дутуу тооцон олгож, татвар шимтгэлийг суутгаагүй зэрэгтэй холбоотой 113.2 сая төгрөг

Сумдын ИТХ-ын тойрогт ажиллах, чадавхжуулах зардлын зарцуулалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт зэрэгтэй холбоотой (7 байгууллага) 75.7 сая төгрөг

Илрүүлэлт №3

Аймаг, сумдын төрийн сангийн төлбөр тооцоонд тавих дотоод хяналт хангалтгүйгээс төсвийн сахилга бат алдагдах, төсвийн хөрөнгө үр дүнгүй, зориулалт бус зарцуулагдах эрсдэл үүсэж байна.



Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалттай холбоотой илэрсэн зөрчилд үндэслэн аудитаас сумдын төрийн сангийн хяналтыг сайжруулах, төсөв захирагч, нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтэн, сумын санхүүгийн албаны дарга нарын шат шатны хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх, төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах холбогдох арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Илрүүлэлт №4

Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардалд нийт 413.3 сая төгрөгийг төлөвлөж, 384.4 сая төгрөгийг зарцуулсан. Үүнээс 75.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд тус зардлыг зардлын эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөөгүй, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх болон бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд нэмж төлөвлөн, зориулалт бусаар зарцуулсан зөрчил нийтлэг байна.



ИТХ-ын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардалтай холбоотой илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, сумдын ИТХ-ыг арга зүйгээр ханган ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлээ.

ОНТХО:

Их засварын 14 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 3,405.7 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 13 төсөл арга хэмжээнд 3,134.3 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний дагуу олгож, 103.4 сая төгрөгийг техник хяналтын зардал, чанарын баталгаа болгож хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Авто замын сан:

Нийт 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,397.6 сая төгрөг баталснаас, гүйцэтгэлээр 2 төсөл арга хэмжээнд 1,073.6 сая төгрөгийн санхүүжилтийг гэрээний дагуу олгож, он дамжин хэрэгжиж байгаа 1 ТАХ-ний 200.0 сая төгрөгийн санхүүжилтийг хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сан:

Тайлант онд аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр 397 төсөл арга хэмжээг 17,935.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр шат, шатны ИТХ-аас баталсан байна. Гүйцэтгэлээр 325 төсөл арга хэмжээнд 14,272.6 сая төгрөгийг зарцуулж, 72 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй ОНХС-ийн санд 3,010.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой нийт 727.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 11 албан шаардлага, 2 зөвлөмжийг хүргүүлжээ.

Нэмэлт төсвийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.

Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн харьяа 24 байгууллага нэмэлт санхүүжилтээр нийт 2,986.2 сая төгрөгийг хүлээн авч, 2,593.3 сая төгрөгийг зарцуулж, 392.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 153.8 хувь буюу 1,809.7 сая төгрөгөөр өссөн байна.

БҮЛЭГ 3: Орон нутгийн ТЕЗ-ийн 2024 оны хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт дунджаар 93.2 хувьтай байна

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Аймгийн 2024 оны тодотгосон төсөв батлах тухай” 07 дугаар тогтоолоор “Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг ТЕЗ, түүний хэрэгжүүлэх 20 салбар чиглэлийн дагуу баталж ажилласан бөгөөд Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрсэн үр дүн, зарцуулсан төсөв, түүний танилцуулгыг бэлтгэсэн байна.



Архангай аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

зарим хөтөлбөрийн хүрэх дүн шалгуурыг үндэслэлтэй тооцож төлөвлөж тайлагнах шаардлагатай байна. Тухайлбал: боловсрол, эрүүл мэнд, соёлын байгууллагуудын тухайд орон нутгийн төсвөөс зөвхөн байр ашиглалтын тогтмол зардлыг санхүүжүүлдэг тул тохирох үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж үнэлэхэд анхаарах нь зүйтэй.

Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт:

Аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын хурлын 2023 оны 12 дугаар сарын 07 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг ханган ажиллажээ. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ИТХ-аар авч хэлэлцэн аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 04-ний 06 дугаар тогтоолоор “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

БҮЛЭГ 3: Төрөөс хэрэгжүүлж буй төсвийн бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан байна

Хот хөдөөгийн сэргэлт, шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангах зорилгоор Төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10-20 хувь, орон нутгийн нэмэгдлийг 20-40 хувиар нэмэгдүүлэн, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулал, тэтгэмж олгосон байна.

• Бүтэц орон тооны талаар:

Засаг даргад харьяалагдах 48 байгууллагын хэмжээнд санхүүгийн аудитын явцад авсан судалгаагаар батлагдсан орон тоо 793, гүйцэтгэлээр 768 орон тоогоор ажиллаж 25 орон тоо дутуу буюу сул байгаа нь хүний нөөцийн бүрдүүлэлтэд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Төсвийн шууд захирагчдын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар бүтэц орон тоотой холбоотой 14.1 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрснийг арилгуулах 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хөтөлбөрийн Нэр	Код	Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Баталсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	70105	Хурлын хуралдааныг улиралд 1-с доошгүй, удаа хуралдуулж шийдвэр гаргана, аймгийн ГХУСА33-ийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөг баталж биелэлтийг хангуулж, Гэмт хэргийн зөрчил буура	5,285.3	4,647.6
Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	70106	Засаг даргын харьяа агентлаг, байгууллагуудыг бодлого, удирдлагаар хангаж аймаг, сумдын ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлнэ	38,268.1	35,099.3
Мэргэжлийн хяналт	70417	Эрсдэлд суурилсан аудит, хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо	454.7	427.6
Худалдан авах ажиллагаа	70418	Аймгийн ТЕЗ-ийн харьяаны төсөвт албан газар, орон нутгийн өмчлөгч байгууллагуудын нийт худалдан авалтад эзлэх цэцэг худалдан авалтын хувь	306.9	259.5
Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	70426	Орон нутгийн өмчид бүртгэлтэй, ашиглалтгүй үл хөдлөх хөрөнгийн тоо	322.2	304.4
Орон нутгийн төсөвт орлох орлогын шилжүүлэг	70501	ОНХС-ийн хөрөнгө оруулалтын арга хэмжээг оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх	17,935.3	14,272.6
Мал аж ахуйг хөгжүүлэх	70801	Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо	1,561.9	1,489.4
Ойжуулалт	71403	Ойн нөхөн сэргээлтийн ажил зохион байгуулсан талбай	571.0	526.7
Хүрэллэн буй орны бодлого, удирдлага	71411	Ногоон байгууламжийн өсөлт	1,813.1	1,679.8
Хот байгуулалт, тохижилт	71502	Төсөвт төвлөрүүлсэн төлбөрийн хэмжээ	1,738.9	1,715.4
Нийгмийн эрүүл мэнд	71601	Сумын эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагааны хэвийн жигд байдал	1,137.9	1,101.2
Эмчлэлийн тусламж үйлчилгээ	71602	Ойн нөхөн сэргээлтийн ажил зохион байгуулсан талбай	1,049.8	873.1
Биений тамир спорт	71701	Соёл, урлаг, биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн жигд байдал	693.6	503.9
Соёл урлаг	71702	Соёл, урлаг, биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн жигд байдал	2,177.3	1,321.3
Сургуулийн өмнөх боловсрол	71801	СББ-ын хамран сургалтын цэвэр жин	2,387.4	2,202.0
Ерөнхий боловсрол	71802	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	6,115.0	5,699.3
Мэргэжлийн боловсрол	71804	Нийт төгсөгчдэд мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгчдийн эзлэх хувь	206.7	184.6
Нийгмийн халамж	71902	Халамжийн сангийн хүртээмж	117.7	81.3
Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	72101	Эзэл авсан хоршоо	3,466.6	695.6
Ахмад настны хөгжил хамгаалал	72208	Аймгийн ахмадын хорооны үйл ажиллагааны хэвийн жигд байдал	110.1	110.1
Нийт дүн			85,719.7	73,194.6



Архангай аймгийн ТЕЗ-ийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Илрүүлэлт №5

Худалдан авах ажиллагааны газар, Байгаль орчны газрын дарга буюу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог хуулийн дагуу нөхөх арга хэмжээ аваагүй, аймгийн Засаг даргын захирамжаар 3 удаа түр томилгоо хийсэн. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.



Худалдан авах ажиллагааны газар, Байгаль орчны газрын дарга буюу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог хуулийн дагуу нөхөх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласнаар орон нутгийн төсвөөс 5,070.8 сая төгрөгийг хэмнэсэн ч, зөрчил өмнөх оноос өссөн байна



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад 7 байгууллагатай холбоотой 73.6 сая төгрөгийн дараах зөрчил илэрч, 70.6 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг таслан зогсоох 15 албан шаардлага, 3.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон байна.

Өмнөх онд орон нутгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэй холбоотой 22.1 сая төгрөгийн зөрчил илэрч байсан бол тайланд онд 73.6 сая төгрөг болж өмнөх оноос 3.3 дахин өссөн нь анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

Тайлант онд 140 төсөвт байгууллага урсгал болон хөрөнгийн зардлаас нийт 5,070.8 сая төгрөгийг хэмнэлтийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар нийт 592.6 сая төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах, дотоод хяналтыг сайжруулах талаар аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Аймгийн Засаг даргаас тайлагнасан орон нутгийн 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж 74,384.6 сая төгрөг, нийт зарлага 73,194.6 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажууллаа.
- Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн байна.
- Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 134.1 хувиар буюу 8,390.1 сая төгрөгөөр давж биелсэн байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн зардлыг Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн удирдамжийн дагуу боловсруулж хүргүүлсэн ба төсвийн зарлагын саналыг 15.0 хувиар нэмэгдүүлэн хянасан байна.
- Орон нутгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд батлагдсан урсгал зардлаас зохицуулалт хийлгүйгээр зардлын эдийн засгийн ангилал зөрчиж зарцуулсан байна.
- Аймгийн ТЕЗ-ийн 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу дахин хянаж, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг зөв тодорхойлон баталсан байна.
- Орон нутгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн үнэн зөв тайлагнасан байна.
- Аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж биелэлтийг 91.2%, ИТХ-аас “Хангалттай” гэж үнэлсэн байна.
- Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, аймгийн ТЕЗ-ийн харьяа 43 байгууллагын 190 албан хаагчдад хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 1,397.9 сая төгрөгийн урамшуулал олгожээ.
- Батлагдсан бүтэц орон тооноос 25 орон тоогоор дутуу ажилласан байна
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төсвөөс 5,070.8 сая төгрөгийг хэмнэсэн хэдий ч зөрчил өмнөх оноос өссөн байна
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 83.8 хувьтай байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн ИТХ-ын дарга П.Гомбодорж танаа

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах талаар сумын Иргэдийн төлөөлөгчдийн дарга нар болон ажлын албыг арга зүйн удирдлагаар хангаж, төсвийн зарцуулалтын үр дүнг нэмэгдүүлэн ажиллах

Аймгийн Засаг дарга Б.Цэрэннадмид танаа

- Хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг аймгийн хөгжлийн төлөвлөгөө, засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан, эх үүсвэрийг зардлын зүйлээр нарийвчлан тодорхой төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох нотлох баримтын хамт 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

